



**ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2026 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2026 оны хэлэлцэх асуудлын  
төлөвлөгөө батлах тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1 дэх заалт, “Төрийн орон сууцны корпораци” ТӨХХК-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.3, 9.9 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн орон сууцны корпораци ТӨХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг 1 дүгээр хавсралтаар баталсугай.


2. Батлагдсан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Г.Уянга)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Л.Амгалан)-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Ц.ТҮВШИНЗАЯА



**“ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ” ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Д/д	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хуралд танилцуулах нэгж	Гарах шийдвэр
1	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөө батлах	1 дүгээр сар	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Тогтоол
2	Компанийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлах	1 дүгээр сар	ХЭЗДХГ	Тогтоол
3	Компанийн зохион байгуулалтын бүтцийг шинэчлэн батлах	1 дүгээр сар	ЗУГ	Тогтоол
4	Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх 2025 оны төлөвлөгөөний биелэлтийг хэлэлцэх	2 дугаар сар	Дотоод аудит	
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 онд гаргасан тогтоолын хэрэгжилттэй танилцах	2 дугаар сар	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	
6	ТОСК ТӨХХК-ийн хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөртэй танилцах	3 дугаар сар	ТХГ	
7	Хөгжлийн банкны бондын өр төлбөрийн эргэн төлөлтийн талаарх мэдээлэлтэй танилцах	3 дугаар сар	СХОГ	Тэмдэглэл
8	Компанийн 2025 санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийн тухай сонсож, батлах	4 дүгээр сар	СХОГ	Тогтоол
9	Ногдол ашиг хуваарилах эсэх тухай хэлэлцэж, шийдвэрлэх	4 дүгээр сар	СХОГ	Тогтоол
10	Гүйцэтгэх захиралтай байгуулсан 2025 оны Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэх	4 дүгээр сар	СХОГ, ЗУГ	Тогтоол
11	Гүйцэтгэх захирлын нээлттэй сонгон шалгаруулалтын үр дүнтэй танилцах, гэрээ байгуулах эсэхийг тогтоох	4 дүгээр сар	ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо	Тогтоол
12	Эх үүсвэрээ бие даасан болон хэсэгчилсэн байдлаар шийдвэрлэсэн, байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй, төрийн албан хаагчдын орон сууцны загвар төслийг аймаг орон нутгийн засаг захиргаатай хамтран хэрэгжүүлэх 12 байршилд баригдаж буй 8 айлын буюу нийт 96 айлын орон сууцны барилгын төслийн хэрэгжилттэй танилцах	5 дугаар сар	СХОГ, ТХГ	
13	Түрээсийн орон сууцны сонгон шалгаруулалтын журамтай танилцах	5 дугаар сар	ХАЗГ	Тэмдэглэл
14	ТӨБЗГ-ын 2025 оны хяналт шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний гүйцэтгэлтэй танилцах	6 дугаар сар	ХЭЗДХГ	
15	MNS ISO 37001:2017 Авлигатай тэмцэх менежментийн тогтолцоо стандартын бодлогын хэрэгжилттэй танилцах	6, 9 дүгээр сар	ХЭЗДХГ	Тэмдэглэл

16	Компанийн 2026 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийн явцтай танилцах	6, 10 дугаар сар	ХЭЗДХГ	Тэмдэглэл
17	Компанийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний биелэлтийн явцтай танилцах	7, 11 дугаар сар	СХОГ	Тэмдэглэл
18	Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээ хийх 2026 оны төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийн явцтай танилцах	7 дугаар сар	Дотоод аудит	Тэмдэглэл
19	Үндэсний аудитын газраас өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийн явцтай танилцах	8 дугаар сар	СХОГ	Тэмдэглэл
20	Хөрөнгийн зохицуулалтын асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх	12 дугаар сар	СХОГ	Тогтоол
21	Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлтэй танилцах	Хагас жил тутам	ЗУГ	Тэмдэглэл
22	Төлөөлөн удирдах зөвлөлөөс компанийн удирдах ажилчдад өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт сонсох	Улирал бүр	Нэгжийн дарга нар	Тэмдэглэл
23	Засгийн газар, Хувьцаа эзэмшигч, ТӨБЗГ болон бусад төрийн захиргааны байгууллагаас гаргасан тогтоол шийдвэрийн хэрэгжилт сонсох	Тухай бүр	ЗУГ	Тэмдэглэл
24	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж буй өр, авлагын асуудалтай танилцаж, шийдвэрлэх	Тухай бүр	ХЭЗДХГ, СХОГ	Тэмдэглэл
25	ТУЗ-ийн дэргэдэх Хороод ажиллах	Тухай бүр		
26	Бусад	Тухай бүр		